



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам”-ын 1.3 дахь заалтыг “Нийтийн эдэлбэрийн газарт Газрын тухай хуулийн 12.2-т заасан газар хамаарах бөгөөд зориулалтыг нь өөрчлөхгүйгээр орон сууц, гэр хорооллын бүсэд хийгдэх гудамж, зам, талбай, дугуйн зам, бичил цэцэрлэг, ногоон байгууламж, амралт зугаалга, биеийн тамирын талбайн тохижилтын ажлыг энэ журамд хамруулахгүйгээр Хот байгуулалтын тухай, Барилгын тухай хууль болон холбогдох норм, дүрэм, журмын дагуу аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын эрх, үүргийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжүүлнэ.” гэж өөрчилсүгэй.

2. Энэхүү журмын нэмэлт, өөрчлөлтийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд даалгасугай.

САЙД



Б.МӨНХБААТАР

151030212